



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 226

Улаанбаатар хот

Г “Ард даатгал” ХХК-д дүрмийн сан Г
/хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээндээ
өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3 Даатгалын тухай хуулийн 21.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 355 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Ард даатгал” ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээг тус компанийн 2012 оны хуримтлагдсан ашгаас 750,000,000 /Долоон зуун тавин сая/ төгрөгөөр нэмэгдүүлж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Нэмэлт хөрөнгө оруулалт	Эцсийн үлдэгдэл	
1	“Интер групп интернейшнл” ХХК	659 999 718.60	247 499 894.47	907 499 613.07	33.00
2	Вэнчэрс Уан Б.В	446 220 093.71	167 332 535.14	613 552 628.85	22.31
3	Ц.Тогтохбаяр	539 752 113.35	202 407 042.50	742 159 155.85	26.99
4	Д.Чулуунцэцэг	220 028 046.20	82 510 517.33	302 538 563.53	11.00
5	Б.Мөнхөө	93 800 019.69	35 175 007.39	128 975 027.08	4.69
6	Н.Эрдэнэтулга	40 200 008.45	15 075 003.17	55 275 011.62	2.01
7	Нийт	2 000 000 000.00	750 000 000.00	2 750 000 000.00	100.0

2. Дүрмийн сангийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2013 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Ард даатгал” ХХК /Д.Чулуунцэцэг/-д үүрэг болгосугай.

000382

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН